



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/381

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 318 дугаар тогтоол, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн “а” дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. “Ховд хотын төвлөрсөн хур хогийн цэгт цахилгаан татах”, “Цамбагарав багийн 8 дугаар гудамжны эрчим хүчний 6000 квт-ын шугам сүлжээг шилжүүлэх” ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б. Баярсүх - Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

- Гишүүд: Ш.Мөнхзаяа - Эрчим хүчний хяналтын Улсын байцаагч
- Д.Эрдэнэбат - Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн гэрээт ажилтан
- А.Пүрэвдорж - “Ховд цахилгаан түгээх сүлжээ” ХХК-ний ерөнхий инженер
- Нарийн бичгийн дарга: Х.Баасанхүү - Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. “Ховд хотын төвлөрсөн хур хогийн цэгт цахилгаан татах”, “Цамбагарав багийн 8 дугаар гудамжны эрчим хүчний 6000 квт-ын шугам сүлжээг шилжүүлэх” ажлыг төсвийн дагуу шалгаж, хянан баталгаажуулж шийдвэр гаргаж хүлээн авахыг ажлын хэсгийн ахлах / Б. Баярсүх /-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ  Т.ЖАРГАЛСАЙХАН



02 01666  
D/Zah-A/381- Bo